



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/14

Арвайхээр


Хөдөлмөрийн дотоод журмыг
шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1, 130.2 дахь заалт, Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/78 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын хэлтсийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг тус хэлтсийн ажилтан, албан хаагчдад, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасаг /А.Ганчимэг/-т, журамд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг жил бүрийн төсөвт тусгахыг нягтлан бодогч /О.Отгончимэг/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Татварын хэлтсийн даргын "Журам батлах тухай" 2016 оны А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН.ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Н.ЭРДЭНЭСУВД



106181027